



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШУ	Шинжлэх ухаан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.УЯНГА ТАНАА**

2025-02-25 № ДАА-2025/1975/НА-ОТА-ТМБ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, 12,800.9 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

432502260

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхү үгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Б	1	2
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	333,257,724.67	436,885,599.77
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	142,064,044.05	243,403,423.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	142,064,044.05	243,403,423.39
3121	Төгрөг	142,064,044.05	243,403,423.39
31211	Төрийн сангийн харилцах	142,064,044.05	243,403,423.39
33	АВЛАГА	1,400,200.09	1,352,895.32
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,400,200.09	1,352,895.32
35	БАРАА МАТЕРИАЛ	189,793,480.53	192,129,281.06
351	Түүхий эд материал	86,745,696.08	88,856,193.08
35110	Тусгай зориулалттай материал	86,713,696.08	88,824,193.08
35130	Эм боох материал	32,000.00	32,000.00
354	Хангамжийн материал	103,047,784.45	103,273,087.98
35410	Бичиг хэргийн материал	2,961,800.00	00.00
35420	Аж ахуйн материал	34,648,868.65	36,447,665.41
35450	Барилгын засварын материал	2,981,000.00	2,981,000.00
35460	Хүнсний материал	1,568,244.00	1,631,350.00
35470	Бусад хангамжийн материал	60,887,871.80	62,213,072.57
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,368,145,960.20	3,407,823,741.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,368,145,960.20	3,407,823,741.20
392	Биет хөрөнгө	3,144,969,580.60	3,185,985,361.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,127,776,908.46	3,127,776,908.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	-221,340,288.61	-274,702,902.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	235,571,794.00	356,612,194.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-146,314,102.95	-187,340,517.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	222,431,734.50	251,306,734.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-144,456,684.24	-158,535,989.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,150,790.00	26,150,790.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,744,533.00	-10,913,876.96
39217	Ном	54,893,962.44	55,632,021.84
393	Биет бус хөрөнгө	223,176,379.60	221,838,379.44
39301	Програм хангамж	7,290,000.00	7,290,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,911,000.40	-4,249,000.56
39303	Бусад биет бус хөрөнгө	218,797,380.00	218,797,380.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,701,403,684.87	3,844,709,340.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	196,804.77	412,500.00
413	Өглөг	196,804.77	412,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	47,304.77	412,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	149,500.00	00.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,701,206,880.10	3,844,296,840.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	712,076,817.42	712,076,817.42
51101	Өмч: - төрийн	712,076,817.42	712,076,817.42
512	Хуримтлагдсан үр дүн	2,989,130,062.68	3,132,220,023.55
51210	Өмнөх үеийн үр дүн	2,989,130,062.68	2,989,130,062.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	143,089,960.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,701,403,684.87	3,844,709,340.97

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,745,737,942.68	2,245,241,445.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,684,520.20	163,382,864.70
120	Нийтлэг татварын бус орлого	112,684,520.20	163,382,864.70
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	67,066,614.54	120,927,859.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	36,860,357.66	18,088,105.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,757,548.00	24,366,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,143,748.00	4,461,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,613,800.00	19,905,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,633,053,422.48	2,081,858,580.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,497,167,200.00	1,889,907,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,497,167,200.00	1,889,907,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,886,222.48	191,951,480.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,886,222.48	191,951,480.71
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,606,112,964.06	2,102,151,484.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,606,112,964.06	2,102,151,484.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,522,741,863.06	2,018,656,504.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,041,278,932.10	1,405,903,645.99
210101	Үндсэн цалин	750,591,878.10	948,824,291.20
210102	Нэмэгдэл	252,254,305.00	399,243,854.79
210104	Урамшуулал	38,432,749.00	57,835,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,730,294.72	173,819,769.05
210201	Тэтгэврийн даатгал	88,529,360.75	119,365,706.88
210202	Тэтгэмжийн даатгал	10,420,777.76	15,856,207.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,339,800.24	6,962,131.73
210204	Ажилгүйдлийн даатгал	2,038,088.99	6,895,648.72
210205	Эрүүл мэндийн даатгал	20,402,266.98	24,740,074.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,886,222.48	172,951,480.71
210301	Гэрэл, цахилгаан	25,633,787.48	35,186,973.96
210302	Түлш, халаалт	82,069,264.00	119,272,032.75
210303	Цэвэр, бохир ус	12,183,171.00	18,492,474.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	19,000,000.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,134,400.00	31,404,863.44
210801	Бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,296,400.00	3,368,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,838,000.00	28,035,963.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,712,013.76	215,576,745.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,773,285.00	94,293,016.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,001,650.00	10,308,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,937,078.76	110,975,678.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,371,101.00	83,494,980.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,371,101.00	83,494,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66,660,001.00	66,853,780.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,711,100.00	16,641,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	139,624,978.62	143,089,960.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,321,491.68	00.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,321,491.68	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-8,321,491.68	00.00
5	НИЙТ ҮР ДҮН	131,303,486.94	143,089,960.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,641,810,970.48	2,106,225,480.71
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,757,548.00	24,366,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,757,548.00	24,366,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,757,548.00	24,366,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,143,748.00	4,461,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,613,800.00	19,905,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,633,053,422.48	2,081,858,580.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,497,167,200.00	1,889,907,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,497,167,200.00	1,889,907,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,886,222.48	191,951,480.71
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,886,222.48	191,951,480.71
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,477,019,455.58	1,975,160,501.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,477,019,455.58	1,975,160,501.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,392,396,290.58	1,891,452,915.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,049,235,895.10	1,404,689,725.02
210101	Үндсэн цалин	750,591,878.10	877,538,612.48
210102	Нэмэгдэл	260,211,268.00	469,315,612.54
210104	Урамшуулал	38,432,749.00	57,835,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,923,437.00	174,621,190.02
210201	Тэтгэврийн даатгал	88,576,665.70	120,213,115.11
210202	Тэтгэмжийн даатгал	10,420,777.76	14,098,818.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,339,800.24	7,051,358.97
210204	Ажилгүйдлийн даатгал	2,038,088.99	6,649,239.56
210205	Эрүүл мэндийн даатгал	20,548,104.31	26,608,658.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,886,222.48	172,951,480.71
210301	Гэрэл, цахилгаан	25,633,787.48	35,186,973.96
210302	Түлш, халаалт	82,069,264.00	119,272,032.75
210303	Цэвэр, бохир ус	12,183,171.00	18,492,474.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,000,000.00	19,000,000.00
210604	Урсгал засвар	16,000,000.00	19,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,134,400.00	31,404,863.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,296,400.00	3,368,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,838,000.00	28,035,963.44
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,216,336.00	88,785,656.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,369,800.00	71,246,556.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,846,536.00	17,539,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,623,165.00	83,707,586.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,623,165.00	83,707,586.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж,	67,912,065.00	67,066,386.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,711,100.00	16,641,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	164,791,514.90	131,064,979.34
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	42,188,000.00	29,725,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,188,000.00	29,725,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,188,000.00	29,725,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,188,000.00	29,725,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-42,188,000.00	-29,725,600.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	122,603,514.90	101,339,379.34
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,460,529.15	142,064,044.05
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	142,064,044.05	243,403,423.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	712,076,817.42	00.00	2,989,130,062.68	3,701,206,880.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	712,076,817.42	00.00	2,989,130,062.68	3,701,206,880.10
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	143,089,960.87	143,089,960.87
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	712,076,817.42	00.00	3,132,220,023.55	3,844,296,840.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,251,209,300.00	2,004,886,101.37	246,323,198.63	89.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,251,209,300.00	2,004,886,101.37	246,323,198.63	89.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,155,148,900.00	1,921,178,515.37	233,970,384.63	89.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,591,744,900.00	1,404,689,725.02	187,055,174.98	88.2
210101	Үндсэн цалин	1,067,283,400.00	877,538,612.48	189,744,787.52	82.2
210102	Нэмэгдэл	485,873,400.00	469,315,612.54	16,557,787.46	96.6
210104	Урамшуулал	38,588,100.00	57,835,500.00	-19,247,400.00	149.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,968,100.00	174,621,190.02	24,346,909.98	87.8
210201	Тэтгэврийн даатгал	135,298,300.00	120,213,115.11	15,085,184.89	88.9

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	15,917,500.00	14,098,818.34	1,818,681.66	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,958,700.00	7,051,358.97	907,341.03	88.6
210204	Ажилгүйдлийн даатгал	7,958,700.00	6,649,239.56	1,309,460.44	83.5
210205	Эрүүл мэндийн даатгал	31,834,900.00	26,608,658.04	5,226,241.96	83.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,564,500.00	172,951,480.71	2,613,019.29	98.5
210301	Гэрэл цахилгаан	31,000,000.00	35,186,973.96	-4,186,973.96	113.5
210302	Түлш халаалт	125,564,500.00	119,272,032.75	6,292,467.25	95.0
210303	Цэвэр бохир ус	19,000,000.00	18,492,474.00	507,526.00	97.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	19,000,000.00	0	100.0
210604	Урсгал засвар	19,000,000.00	19,000,000.00	0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,673,900.00	31,404,863.44	10,269,036.56	75.4
210801	Бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,369,900.00	3,368,900.00	1,000.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	38,304,000.00	28,035,963.44	10,268,036.56	73.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,197,500.00	118,511,256.18	9,686,243.82	92.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,658,400.00	100,972,156.18	9,686,243.82	91.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,539,100.00	17,539,100.00	0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,060,400.00	83,707,586.00	12,352,814.00	87.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	79,419,200.00	67,066,386.00	12,352,814.00	84.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,641,200.00	16,641,200.00	0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,251,209,300.00	2,106,225,480.71	91,240,819.29	95.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,056,644,800.00	1,889,907,100.00	112,994,700.00	94.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,056,644,800.00	1,889,907,100.00	112,994,700.00	94.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	194,564,500.00	191,951,480.71	2,613,019.29	98.7
132001	Орон нутгийн төсвөөс	194,564,500.00	191,951,480.71	2,613,019.29	98.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	24,366,900.00	-24,366,900.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	Түрээс 4,461,900.00	-4,461,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	Заал, цайнны газар 19,905,000.00	-19,905,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	142,064,044.05	142,064,044.05	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	243,403,423.39	243,403,423.39	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58	58	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	18	18	0	100.0

3 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь “Хамтаараа хөгжсөн, зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод тайлагналын аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143,305.6 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
2	Мөнгөн хөрөнгө	142,064.1	243,403.4	101,339.4
27	Авлага	1,400.2	1,352.9	-47.3
60	Бараа материал	189,793.5	192,129.2	2,335.8
106	Үндсэн хөрөнгө	3,368,145.9	3,407,823.7	39,677.7

137	Нийт хөрөнгө	3,701,403.7	3,844,709.3	143,305.6
138	Өр төлбөр	196.8	412.50	215.7
214	Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,701,206.9	3,844,296.8	143,089.9
215	Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,701,403.7	3,844,709.3	143,305.6

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 243,403.4 мянган төгрөг болж 101,339.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас;
- Бараа материал дансны үлдэгдэл 192,129.2 мянган төгрөг болж 2,335.80 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Боловсролын газар, Боловсролын ерөнхий газраас нийт 17,968.1 мянган төгрөгийн сурах бичиг, бусад хангамжийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 145,093.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 160,726.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,407,823.7 мянган төгрөг болж 39,677.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 29,725.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Боловсролын газар, Дэлхийн зөн олон улсын байгууллага, БШУЯ-аас нийт 120,927.8 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, зөөврийн компьютер, сургалтын техник хэрэгсэл, телевизор, сурагчийн ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, тайлант онд 110,975.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,530,225.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 194,564.5 мянган төгрөг, нийт 1,724,790.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Тайлант онд төсөвт зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,056,644.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 194,564.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, **нийт 2,251,209.3 мянган төгрөгөөр** баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,889,907.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс СНАГ-2025/175/НА-СТА-ТШЗ

191,951.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4,461.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 19,905.0 мянган төгрөг зэрэг **нийт 2,106,225.4 мянган төгрөг** санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд **2,004,886.1 мянган төгрөг** зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,004,886.1 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 199,699.6 мянган төгрөгөөр, бичиг үсгийн боловсролын хөтөлбөрийн зардлыг 19,279.0 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 12,352.8 төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн зардлыг 6,669.2 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,852.6	3,852.6		100.0
2	80312- Сургалт семинар	2,717.8	2,628.4	(89.4)	96.7
3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,844.1	3,835.0	(9.1)	99.8
4	81801- Үдийн цай хөтөлбөр	79,419.2	67,066.3	(12,352.8)	84.4
5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	30,205.6	30,205.6		100.0
6	81823- Боловсролын багшийн сургалт	11,599.2	4,930.0	(6,669.2)	42.5
7	81827- Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	138,906.6	119,627.5	(19,279.0)	86.1
8	81834- Боловсролын стандарт сургалт	1,679,706.6	1,480,006.9	(199,699.6)	88.1
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	67,120.6	66,350.2	(770.4)	98.9
10	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	11,027.4	9,769.4	(1,257.9)	88.6
11	81848-Сурах бичгийн түрээс	3,369.9	3,368.9	(1.0)	100.0
12	83603-Нэмэлт Дээд шатны төсвөөс	90,000	90,000		100.0
13	80233- Хүүхэд хамгаалал	4,098.6	4,097.6	(0.95)	100.0
14	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	8,266.6	4,686.01	(3,580.5)	56.7
15	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	12,420.0	12,420.0		100.0
Дүн		2,056,644.8	1,812,934.6	(243,710.2)	88.2
16	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	194,564.5	191,951.5	(2,613.0)	96.7
Нийт		2,251,209.3	2,004,886.1	(246,323.2)	89.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй

холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул Галил Этос ХХК, Шунхлай петролиум ХХК, Цахим ертөнц ХХК, Түшиг бүрэн хан ХХК, Сэлэнгэ менежмент ХХК, Хонгор мөрөн компьютер ХХК, Ц.Цэсэм, Л.Цэджав, С.Анхтуяа, Д.Тулга, Б.Нямаа, Ц.Ганбаатар, С.Энхтайван нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлын 1,606,113.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,091.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 166 мэдээллийг байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файл, шийдвэрийн хуулбарыг, 3,4,5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээлээгүй байна.

Энэ нь нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "...Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил

илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	149.5	2	149.5	100.0
Зөвлөмж	0		0		0
Нийт дүн	2	149.5	2	149.5	100.0

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар НДШ-ийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй 412.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 10,047.5 мянган төгрөгийн 4 зөрчил² илрүүлж, 3 албан шаардлага, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн 412.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь : Төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2. Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголтгүйгээр зөвхөн 12 сард буюу захирлын 2024 оны 11,12 дугаар сарын Б/59, Б/71, Б/72 дугаар тушаалуудаар нийт 9 багшид 1,750.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж, батлагдсан төсөвт багтаан нэмэгдлийг сар бүр олгож байх албан шаардлага хүргүүлэв.

3.Тус сургууль нь жил бүр заалны түрээс, цайны газрын орлогоос тодорхой хэмжээний үйл ажиллагааны орлого төвлөрүүлдэг атал тайлант онд үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй бөгөөд эдгээрээс төвлөрсөн 7,485.0 мянган төгрөг /заалны 2,820.0 мянган төгрөг, цайны газрын 4,665.0 мянган төгрөг/-ийн орлогыг зарцуулах эрх авч зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” 5.7 дахь “Орлогын төлөвлөгөөгүй төсөвт байгууллагад үндсэн үйл ажиллагааны нэмэлт төсвийг зарцуулах эрх олгохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Хүүхэд хамгааллын ажлаар явсан тайлан, шатахууны зарцуулалтын тайлан, жолоочийн тооцооны хуудас зэрэг анхан шатны баримтгүйгээр хүүхэд хамгааллын зардлаас 400.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргаж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь
“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн
тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна

1.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж,
бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг
Төрийн аудитын тухай хуулийн 20.5³ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг
хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дүгээр сарын 15-
ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-ийн өглөгийг дутуу тайлагнасан	1	412.5	1	412.5			1	412.5				
Дүн	1	412.5	1	412.5			1	412.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллаг ад шилжүүлсэ н асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	412.5			1	412.5						
Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу олгоогүй	1	1,750.0			1	1,750.0						
Төлөвлөөгүй өөрийн орлогыг эрх тавиулж	1	7,485.0			1	7,485.0		-				

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зарцуулсан												
Анхан шатны баримтын бүрдэлгүй	1	400.0					1	400.0				
Дүн	3	10,047.5				3	9,647.5	1	400.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд мэдээлбэл зохих 3 мэдээллийг мэдээлээгүй, хавсралт файл оруулаагүй	1							1	
Дүн	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1							1	



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 150/А/150325

Сүхбаатар

00А-2025/175/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 412.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн захирал П.Уянга, нягтлан бодогч Ц.Оюунгэрэл нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504450



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 156 /АБ30315
УТН-2025/175/НА-СТН-ТШЗ

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар тайлант онд үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй бөгөөд эдгээрээс төвлөрсөн 7,485.0 мянган төгрөгийн орлогыг зарцуулах эрх авч зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/-ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” 5.7 дахь “ Орлогын төлөвлөгөөгүй төсөвт байгууллагад үндсэн үйл ажиллагааны нэмэлт төсвийг зарцуулах эрх олгохгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны орлогыг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах эрх авч зарцуулж ажиллан, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн захирал Л.Уянга, нягтлан бодогч Ц.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504467



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

144/А/БД 385

Сүхбаатар

00А-2025/175/НА-ОТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголгүйгээр зөвхөн 12 сард буюу захирлын 2024 оны 11, 12 дугаар сарын Б/59, Б/71, Б/72 дугаар тушаалуудаар нийт 9 багшид 1,750.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/1, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 6-д "Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно", 7-д "Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Багш ажилтнуудын ур чадварыг журмын дагуу үнэлж дүгнээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 3 дугаар сургуулийн захирал Л.Уянга, нягтлан бодогч Ц.Оюунгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504432

